



САЯХАН ТӨРСӨН ХҮҮХДЭЭ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ХЭРХЭН ДААТГУУЛАХ ВЭ?

▶ Байнгын оршин суух зөвшөөрөлтэй, орогнол цагаач, олон улсын хамгаалал хүссэн, Чех улсад ажилладаг эсвэл хувиараа аж ахуй эрхэлж буй Европын холбооны иргэдийн хүүхэд **төрсний дараа нийгмийн эрүүл мэндийн даатгалд шууд хамрагдана.**

- Та хүүхдээ яг төрснөөс хойш (хүүхдийн байнгын оршин суух зөвшөөрлийг авахын өмнө) эрүүл мэндийн даатгалын газарт бүртгүүлж болно. Үүнд өөрийн иргэний үнэмлэх (паспорт), өөрийн эрүүл мэндийн даатгалын үнэмлэх ба хүүхдийн төрсний гэрчилгээ гурван бичиг баримтыг бүрдүүлнэ. Даатгалын байгууллага **6 сарын** хүчинтэй түр үнэмлэх гаргаж өгнө.
- Хүүхэд **төрснөөс хойш 60 хоногийн дотор** та хүүхдийнхээ оршин суух зөвшөөрлийг хүссэн өргөдөл өгөх ёстой. Та хүүхэддээ оршин суух зөвшөөрөл авсны дараа эрүүл мэндийн даатгалын газарт үзүүлээд цаашид байнга бүртгүүлж байх ёстой.

▶ Урт хугацааны оршин суух зөвшөөрөлтэй эцэг эх хоёр мөн ийм төрлийн оршин суух зөвшөөрөлтэй хүүхдэд **цогц эрүүл мэндийн даатгал** хийлгэх ёстой. Энэ даатгал нь нийтийн эрүүл мэндийн даатгалтай төстэй эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг, даатгалд үндсэн ба урьдчилан сэргийлэх эмчилгээ, хүүхдэд заавал хийлгэх вакцин хамрагдана, гэхдээ олон онцлог, өөр өөр хэмжээтэй байж болно. Эрүүл мэндийн даатгалын компаниудын нөхцөлүүд их ялгаатай байна. Даатгалын гэрээний нөхцөлийг дэлгэрэнгүй судлаж уншаарай.

- Хүүхэд эрүүл мэндийн даатгал хийлгэхээс өмнө даатгалын компанийн эмчид урьдчилан хянуулдаг. Тухайн даатгалын байгууллага хүүхдийг даатгахаас татгалзаж болно.
- Хүүхдийн эрүүл мэндийн даатгал хүүхэд төрснөөс хойш хийгдэж болно. Хийхээс өмнө хүүхэд даатгалгүй байвал түүний эмчилгээний зардалыг та өөрөө төлнө.
- Эх хүн **жирэмсэн ба хүүхэд төрөх үед хийх эмчилгээний даатгалд хамрагдсан** бол хүүхэд төрснөөс хойш эмнэлгээс гарах хүртэлх нялх хүүхэд хийх эмчилгээг хамардаг. Гэхдээ энэ үйлчилгээнд хүүхдийн 3 сар хүртэлх хугацаанд хийсэн үйлчилгээ ба эрүүл мэндийн даатгалын гэрээний мөнгөнөөс илүү гараагүй тохиолдолд эмчилгээний зардалыг нөхөн төлөгддөг.

! Таны ажлын зөвшөөрөл хүчинтэй мөн ажил олгогчтой хийсэн ажлын гэрээ хүчинтэй үүний үндсэн дээр та урт хугацааны оршин суух зөвшөөрөлтэй байгаа тохиолдолд та нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан хэвээр байна. **Харин таны хүүхэд нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй юм.**

▶ Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл доорх хаягаар ороорой:
www.cicpraha.org/infoservis

Хэрэгтэй сайтууд: **<http://www.pvzp.cz>**, **<http://www.domavcr.cz>**,
<http://www.mighealth.net>, **<http://portal.gov.cz>**

▶ **CENTRUM PRO INTEGRACI CIZINCŮ o. s.**

Kubelíkova 55, 130 00 Praha 3
Tel./fax: (+420) 222 713 332, Email: info@cicpraha.org

Дунд Чех нутгийн ЦИЦ байгууллагийн салбар
Zahradní 46, Kolín, Tel.: 774 866 838, **www.cicpraha.org**



ТА ГАДААД ХҮН ҮҮ, ХҮҮХЭД ТӨРҮҮЛСЭН ҮҮ?

2011




MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY

Энэ танилцуулга гуравдагч орны иргэний интеграцад зориулан Европын сангаас дэмжлэг авсан төсөл юм.

1

ОДОО ЯАХ ВЭ, ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ? ЮУ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ?

- ▶ Төрөх газар (төрөх газрын эмнэлэг) шинээр төрсөн хүүхдийг байнгын оршин суух газрын Иргэний бүртгэл мэдээллийн товчоонд мэдээлэнэ.
- ▶ Иргэний бүртгэл мэдээллийн товчоо нь хүүхдэд нэг долоо хоногийн дотор Чехийн төрсний гэрчилгээ гаргаж өгнө (төрсний гэрчилгээ бол оршин суух зөвшөөрөл биш).
- ▶ Төрсний дараа 60 хоногийн дотор хүүхэддээ Чех улсад оршин суух зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах ёстой. Эцэг эх хоёрын оршин суух зөвшөөрлөөс хамааран хамгийн зохистой шийдвэр гарна.
- ▶ Хэрэв хүүхдийн эцэг эх хоёрын аль нэг нь Чех улсын харъяат нөгөө нь гадаад хүн байвал хүүхэд Чех улсын иргэний харъяалал эзэмшинэ, харъяалал хүссэн өргөдөл гаргах хэрэггүй. Хүүхэд нөгөө гадаад улсын иргэний харъяалалтай байж болно.
- ▶ Та өөрийн элчин сайдын яаманд хүүхдээ өөрийн паспортод бүртгүүлэн тэмдэглүүлэх эсвэл хүүхдэд өөрт нь паспорт гаргуулах ёстой. (Орогнол хүсэгч цагаач ба түр хамгаалал дор байгаа этгээдэд хамааралгүй.)
- ▶ Хүүхдийн эцэг эх хоёр албан ёсоор гэрлээгүй бол Иргэний бүртгэл мэдээллийн товчоо эсвэл шүүх тухайн эрэгтэйг хүүхдийн эцгээр тогтоож мэдэгдэнэ. (Үүнийг жирэмсэн үед буюу хүүхэд төрөхөөс өмнө хийлгэж болно.)
- ▶ Хэрвээ хүүхдийн эцэг тогтоолтын талаар тодорхойлж батлах эсвэл үгүйсгэж татгалзах хүсэлтэй байвал нотлох баримтыг шүүхээр шийдвэрлэнэ. Хүүхдийн эцэг эсвэл эх уг хүсэлтийг хүүхэд төрснөөс хойш 6 сарын дотор шүүхэд гаргах ёстой.
- ▶ Чех улсад хүүхэд бие дааж өөрийгөө тэжээн тэтгэх чадвартай болох хүртэл (ихэвчлэн сургууль төгсгөх эсвэл мэргэжлийн курс төгсгөх хүртэл) эцэг эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг хүлээнэ.
- ▶ Хэрэв гэрлэлт салах тохиолдолд хүүхдийг эцэг эх хоёрын аль нэгийг нь асран хамгаалах болон хөрөнгийн чадварыг харгалзан шүүх шийдвэрлэнэ.
 - Эцэг эх хоёрын аль нэг нь хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй бол эцэг эх хоёрын нэг нь эсвэл хүүхэд өөрөө шүүхэд хандаж болно.



2

ТАНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ?

- ▶ Та байнгын оршин суух зөвшөөрөлтэй хүн, мөн орогногч цагаач, олон улсын хамгаалалт хүссэн этгээд, түр хамгаалалт дор байгаа этгээд, Европын холбооны иргэн, Чех улсад ажиллан амьдрах зорилгоор урт хугацааны оршин суух зөвшөөрөлтэй ба Чех улсад оршин суудаг ажил олгогчоос ажил авсан гадаад хүн таны эрүүл мэндийн үйлчилгээг жирэмсний турш, төрөх үед, төрсний дараа нийгмийн эрүүл мэндийн даатгалаас төлнө.
- ▶ **Хүчин төгөлдөр хөдөлмөрийн гэрээтэй** эмэгтэй жирэмсний болон хүүхэд асарсны тэтгэмж авдаг бол ажилчин шиг нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан хэвээр байна.
- ▶ Чех улсад урт эсвэл түр хугацааны гэр бүлийн оршин суух зөвшөөрөлтэй Чех улсад байрлалтай байгууллагад ажилдаггүй бол **Цогц эмчилгээ (komplexní péče)** гэдэг эрүүл мэндийн даатгалыг зайлшгүй хийлгэх ёстой.
- ▶ **ЦОГЦ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ**
Чех улсад 90 хоногоос дээш урт хугацаагаар амьдарвал цогц эрүүл мэндийн даатгал хийх шаардлагатай. 2011 онд цогц эрүүл мэндийн даатгалын таван даатгалын компаниар хийлгэж болно: Pojišťovna VZP (Даатгал ВЗП), Maxima (Максима), Slavia (Славия), Uniqa (Уника), Viktoria Volksbanken (Викториа Волксбанкен).
Энэ даатгал нь нийтийн эрүүл мэндийн даатгалтай **төстэй** эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг, гэхдээ олон онцлог зүйл дээр хязгаарлалтай байж болно. Эрүүл мэндийн даатгалын компаниудын гэрээний нөхцөл ба эмчилгээний үнэ хоорондоо их ялгаатай. Тийм учраас даатгалын компаниудын гэрээний нөхцөл ба саналуудтай сайтар танилцаарай. Цогц эрүүл мэндийн даатгалаар даатгуулах хугацаа хамгийн багадаа 6 сараас (VZP гэдэг даатгалд 4 сараас) хамгийн уртдаа хоёр жил хүртэл байж болно. Даатгасан гэрээний төлбөрийг урьдчилан төлөх үүрэгтэй.
 - Цогц эрүүл мэндийн даатгал нь олон янзын үйлчилгээтэй байна. **Үндсэн стандарт үйлчилгээ нь зөвхөн жирэмслэхээс өмнөх, жирэмсний үеийн тусгай хугацааг хамардаг** („čekací doba“ гэдэг хүлээх хугацаа) **энэ даатгалтай болох нөхцөл бүрдвэл жирэмсэн ба хүүхэд төрөх үед хийх эмчилгээг хамрана.**
 - Жирэмсэн ба хүүхэд төрөх үед хийх эмчилгээг даатгалд хамрагдахын тулд **даатгалын тусгай үйлчилгээг** хийлгэж болно (VZP Pojišťovna-д „Novorozenec [Нялх хүүхэд]“ гэдэг үйлчилгээ, Slavia-д „Máma a miminko [Ээж хүүхэд хоёр]“ гэдэг үйлчилгээ, Uniqa-д „Komplex 2 [Комплекс 2]“ гэдэг гэх мэт үйлчилгээ). Ийм даатгалын үйлчилгээ нь хүүхэд төрснөөс хойш эмнэлгээс гарах хүртэлх нялх хүүхэд, эхэд хийх эмчилгээг хамардаг.
- ▶ Хүлээх хугацаа (**čekací doba**) ба даатгал хүчин төгөлдөр эхлэхтэй (**začátek pojistného plnění**) сайтар танилцаарай. Хүлээх хугацаа ба даатгал хүчин төгөлдөр эхлэхтэй сайтар танилцаарай. (*Жишээ нь: Жирэмсний хүлээх хугацаа 3 сар байна – таны хийсэн даатгал хүчин төгөлдөр эхлэхээс хойш 3 сарын дотор жирэмсэн болвол энэ даатгал жирэмсэн үед хийх эмчилгээг хамрагдахгүй. Төрөхийн хүлээх хугацаа 8 сар байж болно – таны хийсэн даатгал хүчин төгөлдөр болсноос хойш 8 сарын дотор хүүхэд төрвөл даатгалын байгууллага төрөх үед хийх эмчилгээг төлөхгүй.*) Жирэмсэн ба хүүхэд төрөх үед хийх эмчилгээг хамарсан тусгай даатгалын үйлчилгээнд ийм хүлээх хугацаа ихэвчлэн байдаггүй. Тиймээс ийм тусгай даатгалын үйлчилгээг та жирэмсэн үедээ хийлгэж болно. Гэхдээ илүү үнэтэй ба даатгуулах хугацаа хамгийн багадаа 12 сартай байгаа.
- ▶ Та ямар ч эрүүл мэндийн даатгалгүй эсвэл таны хийлгэсэн эрүүл мэндийн даатгал жирэмсэн ба хүүхэд төрөх үед хийх эмчилгээг хамрагдахгүй бол жирэмсэн, хүүхэд төрөх мөн төрсний дараа авсан эрүүл мэндийн үйлчилгээнийхээ зардалыг өөрөө төлөх ёстой. (Энэ нь арван мянгаас дээш корун байж болно, жишээлбэл хүндрэлтэй төрөлт, инкубаторын үйлчилгээ шаардлагатай бол зуун мянган корун байж болно.) Та даатгалтай байсан ч хийсэн эмчилгээний зардал даатгалын гэрээнд тогтоосон хэмжээнээс илүү гарвал та өөрөө нэмэх мөнгө төлөх үүрэгтэй болдог.